

## **“Бэрх Уул” ХК-ийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайлан**

Компанийн нэр: ”Бэрх Уул” ХК

Хаяг: Хэнтий аймаг, Бэрх тосгон (Батноров сум), Уулын үйлдвэрийн байр-01

Утас: 75859505, 99092755

Улсын бүртгэлийн дугаар:	1810002001
Регистрын дугаар:	2643928
Үйл ажиллагааны чиглэл:	Жонш, нүүрс олборлолт
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	108 хувьцаа эзэмшигчид 19,062,080 ширхэг хувьцааг эзэмшиж байна /2016 оны 03 сарын 18- ны өдрийн тархалтын судалгаа/

### **Нүүрс олборлолт:**

2016 онд Чандганы нүүрсний уурхайд 163300 м<sup>3</sup> хөрс хуулж, 32,000 тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй байснаас 123200 м<sup>3</sup> хөрс хуулж, 16630 м<sup>3</sup> хөрс цэвэрлэгээний ажлыг нэмж гүйцэтгэн Хэнтий аймаг болон бусад сумдын хэрэглэгчдийн хэрэгцээнд 42281.5 тонн нүүрс олборлон борлуулалт хийсэн.

Өнгөрсөн жилийн хувьд хөрс хуулалтын ажлыг 7-р сарын 25-аас 10-р сарын 01-ны хооронд гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд төсөвт суусан халаалтын зардал дууссан, төсөвт байгууллагаас авах халаалтын авлагаа авч чадахгүй байна гэдэг тайлбартайгаар 7-р сарын 25-ны байдлаар нэлээдгүй хэмжээний өртэй гарсан. Иймээс 2016 оны уулын ажлын төлөвлөгөө ёсоор хөрс хуулалтын ажлыг 7-р сард эхлэх байсан хэдий ч дээрхи авлагын асуудлаас болоод 2015-2016 оны халаалтын улиралд ажиллах техникийн урсгал засварын ажил болон хөрс хуулалтын ажил төлөвлөгөөний дагуу эхэлж чадахгүйд хүрсэн.

Дээрхи аж ахуйн нэгж, байгууллагуудаас авлагаа цаг тухайд нь авч чадаагүйн улмаас техникүүдийн урсгал засвар болон хөрс хуулалтын ажил хойшлогдож, орон нутгийн өвөлжилтийн байдалд хүндрэл учрах эрсдэлтэй байсан тул 2.4 м<sup>3</sup>-ын шанагатай эксковаторыг 08-р сарын 25-аас 09-р сарын 25 хүртэл, 3.2 м<sup>3</sup>-ын шанагатай эксковаторыг 09-р сарын 25-аас 10-р сарын 20 хүртэл, 14 м<sup>3</sup>-ын тэвшний багтаамжтай 6 ширхэг Nowo маркын автосамосвалуудыг түрээслэн 123200 м<sup>3</sup> хөрс хуулалтын ажлыг 8-р сарын 25-аас 10-р сарын 20-нд бүрэн хуулж дууссан.

Чандганы нүүрсний уурхайн 2016 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд 11.34 сая төгрөг зарцуулна гэж төлөвлөснөөс 5.88 сая төгрөг зарцуулан ажилласан.

### **Тусгай зөвшөөрөл:**

Тус компани нь MV-04590, MV-00166, MV-10965 гэсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрлүүдийн төлбөр хугацаандаа төлөгдөн явж байгаа.

### **Компанийн 2016 оны орлого үр дүнгийн тайлан, баланс**

2016 оны байдлаар 42,281.5 тн нүүрс борлуулж 890,55 сая төгрөгийн орлого, ББӨ 543,0 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 2,464.45 сая төгрөг, үйл ажиллагааны бус алдагдал буюу долларын ханшийн зөрүүний алдагдал нь (4062.18) сая төгрөг болж, нийт энэ онд (6191.43) төгрөгийн алдагдалтай ажилласан.

Компаний үйл ажиллагааны зардал 2,464.45 сая төгрөгийн зардлыг ерөнхийд нь задалж үзэхэд:

1. Ерөнхий удирдлагын зардал 409,77 сая төгрөг
2. Зээлийн хүүгийн зардал 2054,68 сая төгрөг

№	Орлого үр дүнгийн тайлан	2015 он	2016 он
1	Борлуулалт	695.73	890.55
2	ББӨ	618.27	543.00
3	Нийт ашиг	77.46	347.55
4	Бусад орлого	8.18	6.58
5	Ерөнхий удирдлагын зардал	560.27	409.77
6	Санхүүгийн зардал	1735.85	2054.68
7	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-2,210.48	-2,110.32
8	Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	-17.01	-18.93
9	Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	-705.41	-4062.18
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-2,932.90	-6,191.43
11	Орлогын татварын зардал	0.11	0.04
12	Татварын дараах ашиг (алдагдал)	-2,933.01	-6,191.47

№	Хураангуй баланс	2015.12.31	2016.12.31
1	<b>ХӨРӨНГӨ:</b>		
2	Эргэлтийн хөрөнгө	327.59	297.36
3	Эргэлтийн бус хөрөнгө	12,243.23	12,182.67
4	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,570.82</b>	<b>12,480.03</b>
5	<b>ӨР ТӨЛБӨР:</b>		
6	Богино хугацаат өр төлбөр	5,831.47	9,415.04
7	Урт хугацаат өр төлбөр	26,315.91	28,833.01
8	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:</b>	<b>32,147.37</b>	<b>38,248.05</b>
9	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
10	Хувийн өмч	1,906.21	1,906.21
11	Хуримтлагдсан ашиг	-21,482.76	(27,674.23)
12	<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН</b>	<b>-19,576.55</b>	<b>-25,768.02</b>
13	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,570.82</b>	<b>12,480.03</b>

**Чандганы нүүрсний уурхайн хэсэг:**

2016 онд Чандганы нүүрсний уурхай нь хөрс хуулалтын ажлыг “Юнайтед транс” ХХК-иар амжилттай гүйцэтгүүлсэн. Нүүрсний борлуулалт болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ашиг алдагдлыг сүүлийн 3 жилээр тооцож үзвэл:

№	Төрөл	Хэмжих нэгж	2014	2015	2016
1	Нүүрсний борлуулалт тн	Тн	28,775.0	33,031.5	42,281.5
2	Нүүрсний борлуулалт үнэ	сая. төг	605.29	695.73	890.55
3	ББӨ	сая. төг	497.14	618.27	543.00
4	Нийт ашиг	сая. төг	108.15	77.46	347.55

**2016 оны татвар, нийгмийн даатгалын шимтгэлд:**

Компани нь санхүүгийн тайлан баланс болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан цаг хугацаанд нь төлж барагдуулж байгаа.

2016 онд татварт 170,8 сая төгрөг төлж 64,1 сая төгрөгийн өртэй, мөн нийгмийн даатгалын шимтгэлд 111,7 сая төгрөг төлж 25,0 сая төгрөгний өртэй гарсан.

№	Татварын төрөл	2016 оны эхний үлд	Үүссэн	Төлсөн	2016 оны эцсийн үлд
1	Агаарын бохирдол	6,189,750	21,140,780	27,330,530	-
2	АМНАТ	6,477,021	22,263,542	28,740,563	-
3	ААНОАТ	(3,239,000)	19,578	10,000	(3,209,422)
4	НӨАТ	52,730,353	61,150,592	69,000,000	44,880,945
5	ХАОАТ	24,582,868	30,387,986	32,498,481	22,472,373
6	Сууган 10	1,884,000	888,000	2,772,000	-
7	АТӨЯХАТ		655,300	655,300	-
8	ҮХХАТ		6,472,362	6,472,362	-
9	Газрын төлбөр		1,284,295	1,284,295	-
10	Бууны татвар		120,000	120,000	-
11	Татварын акт		1,983,894	1,983,894	-
Татварын нийт дүн		88,624,992	146,366,329	170,867,425	64,143,896
НД-н шимтгэл		63,955,275	72,792,542	111,747,817	25,000,000

№	Татварын төрөл	Эхний үлд	Үүссэн	Төлсөн	Эцсийн үлд
1	Татвар	88,624,992	146,366,329	170,867,425	64,143,896
2	Нийгмийн даатгал	63,955,275	72,792,542	111,747,817	25,000,000
<b>Нийт дүн</b>		152,580,267	219,158,871	282,615,242	89,143,896

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2016 онд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	Khanate Resource Holding	51,8%
2	Khanate Resource Holdings-2 SARL	31,2%
3	BEU Holding S.A.R.L	10%
4	Khanate Resource Holding-3 SARL	6,6%
<b>Нийт</b>		<b>99,6%</b>

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын мэдээлэл:

“Бэрх Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04 сарын 29-ны өдөр хуралдаж компанийн ТУЗ-ийн гишүүдийн томилох, 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлах, 2016 оны бизнес төлөвлөгөө батлах, 2016 оны ТУЗ-ын төсөв батлах зэрэг асуудлаар хэлэлцсэн юм. Уг хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 99,66 хувь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2016 оны 05 сарын 23-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Б.Батхуяг, Д.Даянбилгүүн, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Батхуягийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Батбаатар, Т.Тамир, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Батбаатар томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Жэймс Пассин, Б.Батхуяг, Т.Тамир гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Жэймс Пассиныг томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 онд гишүүдийн орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийж байсан. Дээрхи хугацаанд нийт 4 удаа хуралдаж 8 тогтоол батлагдаж гарсан.

- Ногдол ашиг хувиарлах эсэх тухай, орон батлах тухай зэрэг компанийн санхүү эдийн засагтай холбоотой 2 асуудал.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, аудитын байгууллага сонгох, ТУЗ-ын дарга, ТУЗ-ын нарийн бичиг, Гүйцэтгэх захирал томилох, ТУЗ-ын аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо болон цалин урамшууллын хороо сонгох тухай компанийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 6 асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.

Үнэт цаас гаргачийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бадан овогтой Батбаатар	ТУЗ-ийн дарга	дээд
2	Болд овогтой Мэндсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	дээд
3	Жэймс Пассин	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
4	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
5	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
7	Батболд овогтой Батхуяг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Тэрбиш овогтой Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Дармаа овогтой Нарангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

“Бэрх Уул” ХК 2015 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Бэрх Уул” ХК 2014 оны 04 сарын 21-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах